УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ /ТҮР/

Дугаар 01/02776/25

2025 оны 6 сарын 19 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	**Хүсэлтийн дугаар**	*250600718*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*СЭЛБЭ ХОРИН МИНУТЫН ХОТ КОРПОРАЦ, РД:7105697*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Чингэлтэй 18-р хороо, Сүхбаатар 14-р хороо*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Барилгын түр тэжээл*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1.5.1) Нийслэлийн засаг даргын 2025-02-12-ны өдрийн №А/174 тоот захирамж*
		1.5.2) Нийслэлийн засаг даргын 2025-02-20-ны өдрийн №А/250 тоот захирамж
		1.5.3) Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн 2025-05-06-ны өдрийн №01/90 тоот албан хүсэлт
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*
1.7	**Суурилагдсан хүчин чадал**	*250 кВА* *(Хоёр зуун тавин кВА)*
1.8	**Хүчдэлийн түвшин**	*10kB*

Хоёр. Холболтын цэг

2.1	-110/35/10 кВ-ын Сэлбэ дэд станцын 10 кВ-ын Хангай фидерийн КТПН-5710 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /250 кВА/
2.2	35/10 кВ-ын Төгөл дэд станцын 10 кВ-ын 7 буудал фидерийн КТПН-5859 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /100 кВА/
2.3	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Чингэлтэй фидерийн АТП-2241 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /150 кВА/
2.4	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Чингэлтэй фидерийн КТПН-5858 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /100 кВА/
2.5	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Согоот фидерийн АТП-0050 дэд

	өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /250 кВА/
2.6	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Согоот фидерийн КТПН-1441 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /250 кВА/
2.7	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Согоот фидерийн АТП-5259 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /250 кВА/
2.8	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Чингэлтэй фидерийн АТП-820 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /200 кВА/
2.9	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Чингэлтэй фидерийн АТП-623 дэд өртөөний 0.4 кВ талд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /200 кВА/
2.10	35/10 кВ-ын Төгөл дэд станцын 10 кВ-ын Сэлбэ ЦТП А,Б фидерийн ХТП-6671 дэд өртөөний 0.4 кВталын I ба II секцэд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /100 кВА/
2.11	35/10 кВ-ын Төгөл дэд станцын 10 кВ-ын 7 буудал фидерийн ХТП-675 дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцэд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /100 кВА/
2.12	110/35/10 кВ-ын Дарь эх дэд станцын 10 кВ-ын Чингэлтэй фидерийн ХТП-6146 дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцэд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх. /100 кВА/

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.
3.2	Үйлчилгээний хэсгийн 0.4 кВ талын ерөнхий щитэнд УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, HPLC эсвэл BPLC технологийн модуль бүхий 3 фазын ухаалаг тоолуур, ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/, ачаалалд тохирсон гүйдлийн трансформатор суурилуулах.
3.3	0.4 кВ-ын ерөнхий шитрүү орсон оруулгын кабель бүр дээр тоолуураас өгөгдөл цуглуулж дамжуулах зориулалттай 4G модемтой концентраторыг суурилуулах. Тоолуур болон концентратор нь 1 үйлдвэрийн загвар байх шаардлагатай.
3.4	Мэдээлэл цуглуулах дата концентраторыг заавал үүрэн телефоны сүлжээ дэмждэг газар суурилуулна. Дата концентратор, тоолуур суурилуулахтай холбоотой зөвлөгөөг УБЦТС ТӨХК ХҮАТБХ-ээс тодруулж акт үйлдэнэ.
3.5	Ажлын зураг төслийг зөвшилцөх шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг УБЦТС ТӨХК-аар хянуулсан байх.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Энэхүү техникийн нөхцөл нь барилга баригдаж дуусах хүртэл хүчинтэй бөгөөд цаашид Эрчим хүчний яамнаас олгох үндсэн техникийн нөхцөлийн дагуу түгээх сүлжээнд холбогдохыг анхаарна уу.
4.2	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
4.3	Энэхүү техникийн нөхцөл нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан

тохиолдолд хүчинтэй болно.

4.3.1) Энэхүү техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд түгээх сүлжээнд холбогдсон байх шаардлагатай.

4.3.2) Эх үүсвэр дэд станц, шугам тоноглол хэт ачаалагдсан тул түгээх сүлжээнд 2025, 2026 онд цахилгаан ачаалал нэмэх боломжгүй. Шугам сүлжээнээс 2027 онд 80 кВА чадлаас хэтрэхгүйгээр хангана.

4.3.3) Цаашид эх үүсвэр дэд станц, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэний дараа олгосон бүрэн чадлыг үе шаттайгаар ашиглах боломжтой юм.

4.4 Гадны ззэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд зураг төсөл боловсруулах шатанд эзэмшигчээс зөвшөөрөл авч, зөвшилцсөн байх.

4.5 Шугам тоноглолын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.

4.6 Цахилгаан дамжуулах шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцөн сонгох.

4.7 Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон УБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.

4.8 Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах.

4.9 Түгээх сүлжээний үндсэн шугам нь хэт урт, ачаалал ихтэйгээс шалтгаалан хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх төхөөрөмж сууриуулах болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг УБЦТС ТӨХК-тай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Нэмэлт ажилтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

4.10 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.

4.11 УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

4.12 Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.

4.13 Барилгын талбайд орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус тоноглолын талаар эзэмшигчээс зөвшөөрөл авах.

4.14 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:

4.14.1) Шинээр татах кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох.

4.14.2) Цахилгаан дамжуулах кабель шугам нь 1 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.

4.15 Өвлийн их ачааллын улиралд эрчим хүчний системийн горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц эх үүсгүүрийг бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу.

4.16	Өвлийн их ачааллын горимд тус цахилгаан ачааллыг залгах боломжгүй тул жил бүрийн 11-р сарын 01-ээс 03-р сарын 01 хүртэл ахуйн хэрэглээнээс бусад цахилгаан ачааллыг нэгдсэн системийн зохицуулалтаар хязгаарлах арга хэмжээ авах нөхцөлөөр энэхүү техникийн нөхцөлийг олгов.
4.17	Эрчим хүчний яамны техникийн нөхцөлийн дагуу РП, ХТП барьсаны дараа эдгээр цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг буулгаж УБЦТС ТӨХК-д актаар хүлээлгэн өгөх.
4.18	Барилгын түр тэжээлийн зориулалтаар одоо ашиглагдаж байгаа дэд өртөө, шугам бусад тоног төхөөрөмжийг буулгах зөвшөөрөлийг Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл авахыг анхаарна уу.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугамын “Ажлын зураг төсөл”-ийг ЦБД, ТАД, ААД, ГАБХД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим хүч хэрэглэх дүрмийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан “Техникийн шаардлагын тодорхойлолт”-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагч суурилуулах. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.6	“Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 -д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
5.7	“Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
5.8	“Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.9	Эрчим хүчний зохицуулах хорооны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Холболтын журам”-ын 2.14-д заасны дагуу сүлжээ төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистраль шугам үүсгэхээр хэсэгт иргэн хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр дэд станц, шугам тоноглол барихаар зайлшгүй шаардлага гарч техникийн нөхцөл олгох тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тухайн дэд станц, шугам тоноглолыг шилжүүлэх өгөх.
5.10	Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.

5.11	Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
5.12	Нийслэлийн нутаг дэвсгэрт кабель шугам шинээр татах, шинэчлэх, засварлах үед авто зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн тохижилттой зам талбайг сэтлэх, сүвлэх инженерийн шугам сүлжээ хийх, орц гарц гаргах тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авах.
5.13	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.14	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.15	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд: 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд; 6.1.2) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд. 6.1.3) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно. 6.1.4) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно. 6.1.5) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
6.2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.
6.3	Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.